


NEAR News

Нэгэн Зүүн хойд Ази- Нэгэн хамтын нийгэмлэг NEAR | One Northeast Asia Region, One Community NEAR

2015 оны 3-4 сар 61 дахь дугаар

Vol. 61



"Сакура цэцэглэх үеэр Япон улс, Шиманэ муж"

Энэ сарын мэдээ

NEAR Холбооны үйл ажиллагаа / Холбооны Хэрэг эрхлэх газрын мэдээ / Гишүүн байгууллагуудын мэдээ / Гишүүн орон нутгуудад зохиогдох арга хэмжээ / 2 дахь удаагийн "Миний мэдэх Зүүн хойд Ази" сэдэвт эссэ бичлэгийн уралдааны бүтээлүүдээс

Сэдэвт нийтлэл

"Дэлхийн усны форум -2015" удахгүй болно.

Эргэн дурсахуй

Ярилцлага-Холбооны Хэрэг эрхлэх газарт 1 жил ажилласан гадаадын төрийн албан хаагчдийн сэтгэгдэл



**Зүүн хойд Азийн бүс нутгийн
засаг захиргаадын холбоо**

The Association of Northeast Asia Regional Governments

NEAR News

NEAR News сэтгүүл нь гишүүн байгууллагуудын мэдээг дамжуулах, харилцан мэдээлэл солилцох албан ёсны хэвлэл юм. NEAR Холбооны гол үйл ажиллагаа, гишүүн орон нутгуудын мэдээ, төрөл бүрийн нийтлэл, зарлал зэргийг голчлон нийтэлдэг 2 сар тутмын хэвлэл бөгөөд гишүүн орон нутаг, холбогдох байгууллагуудад үнэгүй тараадаг. Мөн сэтгүүлийг онлайн хэлбэрээр Холбооны вэбсайтад тавьдаг.

NEAR News сэтгүүл гишүүн орон нутгийн нийтийн бүтээл бөгөөд Зүүн хойд Азийн бүсийг сонирхогч хэн бүхэнд нээлттэй.

Сэтгүүлд чанартай нийтлэл, шинэ санаа оноо тусгахыг хүсвэл бидэнд хандана уу.



Vol. 61



Зүүн хойд Азийн 6 улс(Монгол, Орос, Хятад, Япон, Өмнөд Солонгос, Хойд Солонгос)-ын 78 орон нутаг(73 гишүүн орон нутаг, 5 ажиглагч статустай орон нутаг)-аас бүрдэх Зүүн хойд Азийг төлөөлөх орон нутгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны олон улсын байгууллага юм.

Тус Холбоо хамтын хөгжил цэцэглэлт гэсэн үндсэн үзэл санаан дор Холбооны үндсэн дүрмийг баталж, эдийн засаг, хүмүүнлэгийн харилцаа, худалдаа, боловсрол соёлын харилцаа, байгаль орчин, гамшгаас сэргийлэх, хилийн хамтын ажиллагаа, шинжлэх ухаан технологи, аялал жуулчлал, далай загасны аж үйлдвэр, эрдэс баялаг, зохицуулалт, хүүхэд эмэгтэйчүүд, эмчилгээ, газар тариалан зэрэг төрөл бүрийн салбарт өргөн харилцаа, хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлж байна. Европын орон нутгийн хамтын ажиллагааны төлөөлөх байгууллага АЕР, уур амьсгалын өөрчлөлтийн R20 зэрэг олон улсын байгууллагуудтай түншлэлийн харилцаа тогтоох, хамтын төсөл явуулах зэргээр идэвхтэй харилцан Зүүн хойд Ази төдийгүй дэлхийн хэмжээнд харилцаа, хамтын ажиллагааг явуулахад хичээн чармайж байна

NEAR Холбооны үүд хаалга үргэлж нээлттэй байна

Зүүн хойд Азийн бүсэд байршилтай, Холбооны үндсэн үзэл санаатай санал нэг орон нутгийн захиргаад тус Холбооны Бүгд хуралд оролцож, гишүүнээр элсэн орж болно.



Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоо

The Association of Northeast Asia Regional Governments

NEAR Холбооны үйл ажиллагаа

NEAR Холбооны гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн 10-р хурал болно.

Уг хурал 2015 оны 5 дугаар сарын 20-ны өдрөөс 22-ны өдрийг хүртэл БНСУ-ын Кёнсанбүг мужийн Пухан хотод болно. Хуралд Холбооны Хэрэг эрхлэх газраас 2015 онд хийх гол ажлуудын талаар танилцуулна. Тухайлбал Холбооны Ажлын хорооны 10-р хурал зохиох болон Салбар хороодын үйл ажиллагааг

идэвхжүүлэх, Залуучуудыг дадлагажуулах хөтөлбөр хэрэгжүүлэх тухай танилцуулахаар төлөвлөж байна. Хурлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг орон нутгуудад удахгүй хүргэх болно.



Холбооны гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал 2014

Холбооны Хэрэг эрхлэх газрын мэдээ

Холбооны Хэрэг эрхлэх газрын Ерөнхий нарийн бичгийн дарга болон орлогч даргын ажиллах хугацаа дуусгавар болов.



2014 оны 12 сарын 30-ны өдөр ЗХАБНЗЗХ-ны Хэрэг эрхлэх газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ким Жэ Хю болон орлогч дарга Ли Жун Хуаны ажиллах хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан тус газраас 2 даргыг үдэх ажиллагааг зохион байгуулав. Ерөнхий нарийн бичгийн дарга Ким Жэ Хю нь 2011 оны 5 сараас эхлэн ажиллах хугацаандаа Холбооны Хэрэг эрхлэх газрыг Кёнсанбүг мужид удаан хугацаанд

байршуулах, БНСУ-ын Сэжун хот, БНХАУ-ын Жилинь муж, ОХУ-ын Хакасын БНУ-ыг Холбоонд гишүүнээр элсүүлэх болон Европын орон нутгийн холбоо (AER), Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх үйл ажиллагааны дэлхийн орон нутгийн байгууллага (R20)-тай түншлэлийн харилцаа тогтоох зэргээр Холбооны үйл ажиллагаанд томоохон хувь нэмэр оруулсан юм.

Япон улсын Шиманэ мужийн Ицму хотын төлөөлөгчид Пухан хотод айлчлав.

Шиманэ мужийн Ицму хотын ИТХ-ын 7 гишүүн, тус хотын Худалдаа аж үйлдвэрийн танхимын 3 төлөөлөгчөөс бүрдсэн 10 хүний бүрэлдэхүүн 2015 оны 1 дүгээр сарын 19-ний өдрөөс 21-ний өдрийг хүртэл Пухан хотод айлчлав. 20-ны өдөр төлөөлөгчид Пухан хот дахь Поско компаний түүхийн музей, мөн төмрийн үйлдвэрээр явж танилцахын зэрэгцээ Япон, Солонгосын эдийн засгийн хамтын ажиллагаа, ирээдүйн түншлэлийн харилцааг байгуулахад зүтгэл гаргасан, Поско компанийг үндэслэгч, Солонгосын Парламентын гишүүн асан Пак Тэ Жүний дурсгалын хөшөөнд цэцэг өргөв.

Дараагаар нь Пухан хотын ИТХ-ын гишүүд, Худалдаа аж үйлдвэрийн танхим болон судалгааны институтын төлөөлөлтэй уулзан хоёр хотын

хамтын ажиллагааны арга замын талаар хэлэлцэж, санал бодол солилцов. Санал бодол солилцсоны эцэст 2 талаас тус бүр 1 ажилтныг хоёр хотын харилцааг хариуцсан мэргэжилтнээр томилохоор болов. Мөн эдийн засаг, соёл, иргэдтэй харилцах, ИТХ-ын асуудлаар харилцах тус бүр 1 хүн буюу нийт 3 хүн бүхий багийг бүрдүүлэх, хоёр хотын харилцааг өргөжүүлэхийн тулд хамтарсан симпозиум зохиох санал гарав. Түүнээс гадна Ицму хот нь япон үндэсний архи үйлдвэрлэлээр, Пухан хот Солонгост гуамэги хэмээх хатаасан загасаар алдартай тул энэ чиглэлийн үзэсгэлэн зохиож болох тухай ч дурдав. Пухан хот ба Ицму хот хооронд 2009 оноос 2012 он хүртэл хотын Захиргаа, ИТХ, Худалдаа аж үйлдвэрийн танхим хооронд жил бүр харилцаатай байж ирсэн ч 2013



оноос 2014 он хүртэл харилцаа зогсноос хойш энэ удаа дахин харилцааг сэргээх хүрээнд хийж буйгаараа энэ удаагийн айлчлал онцлогтой байв.

Холбооны Хэрэг эрхлэх газрын япон хэлтэй мэргэжилтэн Ицму хотын төлөөлөгчдийг дагалдан Пухан хотод байх хугацаанд нь хэлмэрчилж ажиллав.

NEAR Холбооны Хэрэг эрхлэх газрын төлөөлөгчид олон улсын байгууллагын туршлагаас судлав.

2015 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр Холбооны Хэрэг эрхлэх газрын Бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга Пак Чан Ху тэргүүтэй төлөөлөгчид “Иклей” олон улсын байгууллагын үйл ажиллагаатай танилцах, олон улсын

байгууллагын бүтэц, туршлагаас судлахаар Сүвон хотыг зорив. Иклей байгууллага дэлхийн 84 улсын 1000 гаруй орон нутгаас бүрдэх ба орон нутгийн бодлого, хүчин чадлыг бэхжүүлэхийн төлөө үйл ажиллагаа явуулдаг. Герман улсад

төвтэй уг байгууллагын Солонгос дахь салбар 2012 оны 10 сард байгуулагдаж, Зүүн Азийн төв салбар болон ажиллаж буй бөгөөд Монгол, Хятад, Тайвань, Япон, Хойд Солонгос зэрэг 6 улсыг хамардаг.



Холбооны Хэрэг эрхлэх газрын төлөөлөгчид олон улсын хуралд оролцов.

2015 оны 2 дугаар сарын 23-ны өдрөөс 26-ны өдрийг хүртэл Холбооны Хэрэг эрхлэх газрын Олон улс, хамтын ажиллагааны хэлтсийн дарга тэргүүтэй төлөөлөгчдийн бүрэлдэхүүн “Солонгосын Орон нутгийн захиргаадын нийгэмлэг”-ээс зохион явуулсан “Орон нутгийн захиргаадын олон улсын харилцааг идэвхжүүлэх арга зам” сэдэвт семинарт оролцов. Олон улсын харилцааг өргөжүүлэхэд мэдээлэл хуримтлуулах, олон улсын арга хэмжээ зохион байгуулах арга туршлагаас судлах зорилгоор энэхүү семинарт

оролцсон бөгөөд семинарын дараа Япон улсын Саппоро хотноо “Дэлхийн өвлийн олимпын хотын захирагч нарын байгууллага”-аар айлчилж байгууллагын бүтэц, үйл ажиллагаа зэргийн талаар судлав.

Солонгосын орон нутгийн захирагч нарийн нийгэмлэг 1989 онд байгуулагдсан бөгөөд одоо 1000 гаруй гишүүн, 20 гаруй байгууллагатай хамтран ажиллаж байна. Голдуу орон нутгийн захиргаа болон орон нутгийн захиргаагаар холбогдох салбарын тогтолцоо бодлогын талаар

эрдэм шинжилгээний хурал, арга хэмжээ зохион байгуулдаг. Харин Дэлхийн өвлийн олимпын хотуудын захирагч нарын байгууллага нь 1981 онд байгуулагдсан бөгөөд нийт 9 улсын 20 хот гишүүнээр элссэн. Тус байгууллага нь голдуу гишүүн хотуудын хооронд олон улсын харилцаа, мэдээлэл, боловсон хүчин, залуучуудын солилцооны хөтөлбөр явуулдаг бөгөөд 1997 онд НҮБ-ын зар сурталчилгааны газар болон Эдийн засаг нийгмийн удирдах зөвлөлд ТББ-аар бүртгэгдсэн.

Гишүүн байгууллагуудын мэдээ

Ниншя Хуйн ӨЗО-БНХАУ

Хятад-Арабын улсуудын 2-р үзэсгэлэн болно.



Тус үзэсгэлэн Хятадын Засгийн газраас магадлан итгэмжлэгдсэн, Хятадын Худалдааны яам, Олон улсын худалдааг идэвхжүүлэх хороо, Ниншя Хуйн ӨЗО-ы Ардын засгаас хамтран зохион байгуулдаг нэгдсэн үзэсгэлэн

юм. 2010 оноос “Хятад-Арабын улсын эдийн засаг, худалдааны форум” гэсэн нэрээр энэхүү арга хэмжээг 3 удаа амжилттай зохион явуулсан бөгөөд 2013 оноос хойш “Хятад-Арабын орнуудын үзэсгэлэн” нэртэйгээр зохиох болсон. Өнгөрсөн 5 жилийн хугацаанд нийгмийн 24 зүтгэлтэн, сайдын түвшний 253 өндөр албан тушаалтан, Хятад дахь гадаадын элчин сайдын

яамдын 104 төлөөлөл, төр, олон улсын 70 байгууллага, худалдаа аж үйлдвэрийн 46 танхим, компани, санхүүгийн байгууллагын 6200 хүн буюу нийт 37000 хүн оролцжээ. Нефтьхими, хөнгөн аж үйлдвэр, машин техник үйлдвэрлэл, гэр ахуйн бараа, автомашин угсралт зэрэг төрөл бүрийн чиглэлийн 636 төсөл, гэрээ хэлцэл хийгдсэн. Энэ үзэсгэлэн нь Арабын орнуудаас гадна Исламын шашинт орнуудыг хамарсан арга хэмжээ болохын хувьд Хятад болон холбогдох орнуудын өндөр дээд албан тушаалтнуудын харилцаа төдийгүй улс төрийн харилцаа, эдийн засгийн хамтын ажиллагаа, хүмүүнлэгийн харилцааг эхлүүлэх боломж болж байна. Энэ жил уг үзэсгэлэн Ниншя Хуйн ӨЗО-ы Инчун хотноо болно. Энэ үеэр Торгоны замын бүстэй холбогдох эдийн засаг, худалдаа, интернет технологи, газар тариалан, хүмүүнлэг зэрэг төрөл бүрийн салбарыг хамарсан хурал форум, уулзалт, олон улсын хүнсний үзэсгэлэн болно. Энэ удаагийн үзэсгэлэнд Йордан улс Хятад улстай эдийн засаг, худалдаа, хөрөнгө оруулалт, аялал жуулчлал, соёлын арга хэмжээ зохион байгуулна.

Фүкүй муж-Япон улс

Перу фестиваль болж өнгөрлөө.

2010 онд зохиогдсон АПЕК-ийн Эрчим хүчний яамны сайд нарын хурлын үеэр Япон улсын Фүкүй муж болон Перугийн БНУ-ын хооронд харилцаа тогтоожээ. Тухайн үед Перу улсаас Япон улсад суугаа элчин сайдын зүгээс илтгэл тавих, Перу улс Фүкүй мужийн найрамдлын нийгэмлэг байгуулах, их дээд сургуультай эрдэм шинжилгээний гэрээ хэлцэл хийх зэргээр 2 талын харилцааг явуулахад идэвхитэй ажиллаж, гар бие оролцож байжээ. Энэхүү уламжлалт харилцааг өргөжүүлэхийн тулд Фүкүй мужийн захиргаа Перу улсын элчин сайдын яамтай хамтран 2 дугаар сарын 22-ны өдөр Перу фестивалийг зохион явуулав. Энэхүү фестивалд Перу тогоочийн хийсэн хоол амтлагаа, Перугийн түүх соёл, үндэсний хувцасны үзэсгэлэн гарчээ.



Перу фестиваль 2014

Ишикава муж-Япон улс

Ишикава мужийн хоолны өдөрлөг боллоо.

Өнгөрсөн оны 10 дугаар сард Зүүн Өмнөд Азийн тээвэр мэдээллийн төв хийгээд сүүлийн үед япон хоолыг ихэд сонирхох болсон Сингапурт “Ишикава мужийн хоолны соёлын өдөрлөг” болж өнгөрөв. Уг арга хэмжээнд Ишикава мужийн захирагч Нимото Масанури, Сингапурын нэртэй зочид буудал, рестораны ахлах тогооч, хүнсний үйлдвэр, аялал жуулчлалын компани, төр засаг, эдийн засгийн төлөөлөл оролцжээ.



Ишикава мужийн хүнс хоолыг танилцуулах өдөрлөг

Ишикава мужийн хүнс, амтлагчаар бэлтгэсэн хоол, мөн тус мужийн брэнд архи, зэс таваг зэргээс толилуулжээ. Түүний зэрэгцээ япон үндэсний дуу хөгжмийн тоглолтоос сонирхуулав. 3 дугаар сарын 14-ний өдөр Ишикава мужийн Хокурику Шинкансэн хурдны зам нээгдэж Токио, Канава хүртэл 2 цаг 28 минутад хүрэх юм. Ишикава муж цаашид төрөл бүрийн үйл ажиллагаагаар дамжуулан Ишикава мужийг сурталчилж, мужийн бизнес эрхлэгчдийг Зүүн өмнөд Азийн зах зээлд хөл тавих, Зүүн өмнөд Азийн жуулчдыг татахад хүчин чармайлт гаргах аж.

Кёнсанбүг муж-БНСУ

Кёнсанбүг муж “Дэлхийн ус” форумыг зохиоход бэлдэж байна.



Кёнсанбүг мужаас “Дэлхийн ус” форум зохиоход 3 сарын хугацаа үлдсэнтэй холбогдуулан бэлтгэл ажлыг бүхий л талаар хангаж байна. Дэлхийн усны форум улс төр, бүс, сэдэв бүрээр, шинжлэх ухаан гэсэн 4 ангилал 400 гаруй хэсгээс бүрдэх арга хэмжээнээс гадна аялалын хөтөлбөр багтсан.

Энэхүү форумыг зохиосноор тус мужийн эдийн засгийг идэвхжүүлэх, орон нутгийг тэнцвэртэй хөгжүүлэх төдийгүй усны аж үйлдвэрийн салбарт шинэ алхам болно гэж үзэж байна. Их дээд сургуулийн оюутнуудын усны зам дагасан аялал, “Дэлхийн ус” форумын нэрэмжит чөлөөт бэйсболын өдөрлөг, “Усны түүх” сэдэвт концерт, “Ус” музей зэрэг хөтөлбөрүүдээр дамжуулан хүмүүст усны үнэ цэнийг ойлгуулахаар зорьж байгаа юм.

Кёнсанбүг мужийн захирагч Ким Гуан Юн “Энэхүү форумыг зохион байгуулах эрхийг авснаас хойш дэлхийн усны салбарын удирдлага, компани байгууллагуудтай хамтран ажиллах арга замыг хэлэлцэж ирсэн” бөгөөд “Дэлхийн усны форум”-ыг амжилттай зохион байгуулж, орон нутгийн эдийн засгийг идэвхжүүлэхээс гадна Кёнсанбүг мужийг дэлхийд таниулах болно” гэв.

* “2015 Дэлхийн усны 7-р форум”-ын тухай тусгай нийтлэл булангаас дэлгэрэнгүй мэдээллийг үзнэ үү.

Жэжү муж-БНСУ

“Жэжү-Галын наадам” соёл аялал жуулчлалын шилдэг наадмаар шалгарав.

Жэжү мужийн Галын наадмыг БНСУ-ын Аялал жуулчлалын яамнаас 2015 оны аялал жуулчлалын “Шилдэг наадам”-аар шалгаруулжээ. “Жэжү-Галын наадам” 2006 оноос олонд танигдаж эхэлсэн бөгөөд үхэр, морь зэрэг малын бэлчээрийг сэргээхийн үүднээс өгөр өвсийг шатааж, шавьж устгахын тулд тосгон бүрээр гал тавьдаг байсан Жэжүгийн эртний мал аж ахуйн зан заншил болох “Бан-Эй”-г орчин үед нийцүүлэн гаргасан наадам юм. Энэ жил 18 дахь удаагаа зохиогдох уг наадам 3 дугаар сарын 5-ны өдрөөс 8-ны өдрийг хүртэл “Сэболь Урэм” хэмээх газарт зохионо. 2015 оны Солонгосын соёл аялал жуулчлалын шилдэг наадмын шалгаруулалтад нийт 44 газар оролцсоноос төлөөлөх 2, тэргүүний шилдэг 9, шилдэг 10, нэр хүнд бүхий ангилалд 23 газар тодорсон бөгөөд шилдэг наадмаар шалгарсан газарт 1.5 тэрбум, нэр хүнд бүхий наадмаар шалгарсан газарт 900 сая воны шагнал

олгохоос гадна Солонгосын аялал жуулчлалын удирдах газрын зүгээс эдгээр арга хэмжээг гадаад зар сурталчилгаа, маркетингийн чиглэлээр дэмжиж өгөх ажээ.

Камчатк хязгаар-ОХУ

“Беринг”-Камчаткийн уламжлалт нохойтой чарганы уралдаан болно.

«Беринг» нохойтой чарганы уралдаанд нь сүүлийн 20 гаруй жилийн турш тасралтгүй зохиогдож байгаа төдийгүй, Камчаткийн хязгаарт амьдран сууж буй үндэсний цөөнхийн соёл, уламжлалыг хадгалан



үлдээж, сэргээж буй, дэлхийд энэ төрлийн цорын ганц уралдаан гэдэг утгаар нь уламжлалт хэмээн нэрлэгдэх бүрэн үндэстэй билээ. Анхны “Беринг” уралдаан 1990 оны 1 дүгээр сард зохион байгуулагджээ. Уралдааны замын урт тухайн үед 250 км байсан бол жилийн дараа хоёр дахь удаагаа зохион байгуулагдсан “Беринг-91” уралдааны замын гараанаас бариа хүртэлх зай бараг 8 дахин нэмэгдэн 1980 км болж, дэлхийд хамгийн урт уралдааны замтай нохойт чарганы уралдаан гэдгээрээ Гиннесийн номонд бүртгэгдсэн байна.

2010 онд “Беринг” уралдааныг Камчатк хязгаарын албан ёсны баярын статустай болгож, Камчаткийн хязгаарын Спорт, залуучуудын албан ёсны яамны арга хэмжээний хуанлид оруулжээ. Түүнээс хойш тус уралдаанд оролцогч тамирчид “каюр”-уудын хувьд спортын алдар хүртэх боломжтой болж, шүүгчдийн хувьд уралдааныг шүүх тусгай ангилал бий болсон байна. Беринг” уралдаан нь анх зохион байгуулагдахаасаа эхлэн томоохон хүмүүнлэгийн аян болж өрнөсөн юм. Учир нь уралдаанд оролцогч “каюрууд” жил бүр уралдааны зам дайран өнгөрдөг умрын суурингуудад зориулан хэдэн зуун килограммаар хэмжигдэх хичээлийн хэрэгслэл, ном, спортын тоног төхөөрөмж авчирдаг ажээ.

Уралдаанд Камчаткийн хойгийн бүхий л нутгаас багууд ирж оролцдог. Гарааны цэг байрлах хойд нутагт хүрэх авто зам байхгүй учир тийшээ зөвхөн агаарын замаар л богино хугацаанд туулж очих боломжтой бөгөөд уралдаан эхлэхээс өмнө 7 хоногийн турш баг тамирчдыг гарааны цэг рүү онгоцоор хүргэдэг ажээ. Хэдэн жилийн өмнөөс эхлэн үндсэн их уралдааны өмнөхөн “Дюлин” хэмээх хүүхдийн уралдааныг мөн зохион байгуулж эхэлжээ. Хүүхдийн уралдааны гол шагнал нь сайн үүлдэрийн нохойн гөлөг байдаг бөгөөд Камчаткийн хязгаарын захирагч уг шагналыг гардуулдаг байна. Энэ 2015 онд “Беринг” тэмцээний хүрээнд явагдах цуврал арга хэмжээ болгож, “Зул сарын уралдаан” хэмээх хүүхдүүдийн уралдааныг 1 сарын 06-ны өдөр зохион байгуулсан бол “Беринг-2015” уралдааны хүрээнд явагдах дараагийн арга хэмжээ нь 2 сарын 28-ны өдөр Петровпавловск-

Камчатк дахь Виталий Фатьяновын нэрэмжит биатлоны цогцолборт явагдах нохойтой чарганы уралдаан юм. Энэхүү арга хэмжээнд “Беринг” үндсэн уралдаанд оролцох бүх каюрууд оролцох төлөвтэй байна.

Ингээд Елизово хотод 3 сарын 01-ний өдөр болох уламжлалт “Елизовын уралдаан”-ы дараагаар оролцогч-каюрууд Эссо тосгон руу явж, долоо хоногийн турш үндсэн уралдааны бэлтгэлээ хангаад 3 сарын 7-нд “Беринг-2015” уралдааны нээлтийн ёслол болон уралдааны гараа эхэлж, 3 сарын 8-ны өдөр каюрууд Оссор суурин руу хөдлөх ажээ.

Буриадын БНУ-ОХУ

«Буриад- Амралт, аялал жуулчлал» сэдэвт аялал жуулчлалын үзэсгэлэн яармаг



“Буриад-Амралт, аялал жуулчлал” сэдэвт үзэсгэлэн-яармаг бол Буриад улс, Байгаль нуур орчмын бүсийн аялал жуулчлалын салбарын гол үйл явдал билээ.

Энэ арга хэмжээнээс Орос орны аялал жуулчлалын

ирээдүйтэй бүс нутаг болох Буриадын аялал жуулчлалын салбарын хөгжилтэй танилцаж болно. “Буриад-Амралт, аялал жуулчлал” үзэсгэлэн-яармаг нь уулзалт, яриа хэлцэл хийх, үзэл бодол, санал солилцох талбар болж, Байгаль нуурын бүс нутгийн аялал жуулчлалын салбарын бүтээгдэхүүн, саналуудын талаар бүрэн дүүрэн мэдээлэл авах боломж олгож, нутгийн тур-оператор, тур-компаниудтай урт хугацааны хамтын ажиллагааны гэрээ хэлэлцээр хийх, аялал жуулчлалын тэргүүлэгч компаниудын танилцуулга, үзүүлэн сургалтуудад оролцох гэх зэргээр мужийн аялал жуулчлалыг олон талаар хөхүүлэн дэмжиж буй арга хэмжээ юм.

Тус үзэсгэлэн яармаг нь 11 жилийн турш амжилттай зохион байгуулагдаж, өнөөдөр Байгаль орчмын бүс нутгийн аялал жуулчлалын салбарын томоохон форумд тооцогдох болжээ. Оролцогчдын тоо жилээс жилд улам нэмэгдэж, амралт, сувиллын газар, зочид буудал, ресторан, музей, төрийн байгууллагууд, хүүхдийн зуслан гэх мэт гадаад дотоодын аялал жуулчлалын 100 гаруй байгууллагууд оролцож байна. Гадаадаас Япон, Польш, Монгол улс болон дотоодоос Тувагийн БНУ, Эрхүү муж болон Буриад улсын төлөөлөл жил бүр оролцдог. Өнгөрсөн 2014 оны үзэсгэлэн яармагийг 7 мянга гаруй зочид, мэргэжилтнүүд үзэж сонирхжээ.

Энэ жил 12 дахь удаагийн “Буриадын амралт, аялал жуулчлал” үзэсгэлэн яармаг 2015 оны 4 дүгээр сарын 17-18-ны хооронд зохион байгуулагдана. Үзэсгэлэн яармагийн хөтөлбөрт төрөл бүрийн семинар, дугуй ширээний ярилцлага, аялал жуулчлалын компаниуд, нутгийн захиргааны байгууллагуудын танилцуулга, сугалаа, танилцах аялал зэрэг зочдод зориулсан олон төрлийн арга хэмжээнүүд багтжээ.

Гишүүн орон нутгуудад зохиогдох арга хэмжээ

March


2015.3

Sunday	Monday	Tuesday
•Ангилал : Хэнан муж/ Хятад •Арга хэмжээний нэр : Хааны төрсөн нутагт тахилга үйлдэх ёслол 2015 (2015-Worship Ceremony of The Hometown of The Yellow Emperor) •Хугацаа : 3 сард •Хаана : Шинжон хот •Харилцах хаяг : Жонжоу хотын хороо T.+86-0371-67448741 F.+86-0371-67448741 Website: http://www.zhengzhou.gov.cn	2	3
8	•Ангилал : Хёго муж/ Япон •Арга хэмжээний нэр : Гамшгаас сэргийлэх хорооны 13-р хурал •Хугацаа : 3.9~3.12 •Хаана : Кобэ хот •Харилцах хаяг : Хёго мужийн Гамшгаас сэргийлэх төлөвлөлтийн хэлтэс T.+81-78-362-9870 F.+81-78-362-9914	9
•Ангилал : Тоттори муж/ Япон •Арга хэмжээний нэр : Тоттори марафон 2015 •Хугацаа : 3.15 •Хаана : Тоттори хот •Харилцах хаяг : Тоттори мужийн Соёл, аялал жуулчлал, спортын газрын Спортын хэлтэс T.+81-857-26-7918 F.+81-857-26-8307		10
22	17	•Ангилал : Красноярск хязгаар/ Орос •Арга хэмжээний нэр : 'Енисей медикал' эмчилгээний форум •Хугацаа : 3. 10~12 •Хаана : Красноярск хот •Харилцах хаяг : www.krasfair.ru T. +7 (391) 22-88-611
		24

April

2015.4

•Ангилал : Хэнан муж/ Хятад •Арга хэмжээний нэр : Хэнан-Олон улсын хөрөнгө оруулалт, худалдааны уулзалт, үзэсгэлэн (The Ninth China Henan International Investment & Trade Fair) •Хугацаа : 4 сард •Хаана : Жонжоу хотын Олон улсын үзэсгэлэн, арга хэмжээний төв •Харилцах хаяг : Хэнан мужийн захиргааны Гадаад харилцааны хэлтэс T.+86-0371-65688841 F.+86-0371-65688841 E-mail: faohn05@126.com	5	•Ангилал : Алтайн хязгаар/ Орос •Арга хэмжээний нэр : "Visit Altai" Олон улсын аялал жуулчлалын форум •Хугацаа : 4 сард •Хаана : Барнаул хот Белокуриха хот •Харилцах хаяг : Алтайн хязгаарын Аялал жуулчлалын газар T/F: +7-3852-20-10-31 priem@alttur22.ru	6
•Ангилал : Кенсанбуг муж/Өмнөд Солонгос •Арга хэмжээний нэр : 7дахь удаагийн Дэлхийн усны форум •Хугацаа : 4. 12 ~ 4. 17 •Хаана : EXCO Олон улсын арга хэмжээний төв •Харилцах хаяг : Форум зохион байгуулах хороо8 T.+82-2-6009-9442	12		13
•Ангилал : Кенсанбуг муж/Өмнөд Солонгос •Арга хэмжээний нэр : 7дахь удаагийн Дэлхийн усны форум •Хугацаа : 4. 12 ~ 4. 17 •Хаана : EXCO Олон улсын арга хэмжээний төв •Харилцах хаяг : Форум зохион байгуулах хороо8 T.+82-2-6009-9442	14	•Ангилал : Шаньдун муж/ Хятад •Арга хэмжээний нэр : Шоугуан-Олон улсын хүнсний ногооны шинжлэх ухаан, технологийн 16-р үзэсгэлэн •Хугацаа : 4. 20~5. 30 •Хаана : Вэйфан хот Шоугуан хот •Харилцах хаяг : T.+86-536-5678212	20
19			21

Wednesday	Thursday	Friday	Saturday
4	5	6	7
•Ангилал : Дэгү хот/ Өмнөд Солонгос •Арга хэмжээний нэр : Дэгү-Олон улсын бөс даавууны үзэсгэлэн 2015 (PID) PREVIEW IN DAEGU •Хугацаа : 3.11 ~ 3.13 •Хаана : EXCO Олон улсын арга хэмжээний төв		•Ангилал : Жэжү муж/ Өмнөд Солонгос •Арга хэмжээний нэр : Олон улсын автомашины 2 дахь удаагийн экспо •Хугацаа : 3.6 ~ 3.15 •Хаана : Жэжү муж •Харилцах хаяг : Жэжү мужийн захиргааны Эрчим хүч, аж үйлдвэрийн хэлтэс, Экспо зохион байгуулах хороо T. +064-710-6908	•Ангилал : Нигата муж/ Япон •Арга хэмжээний нэр : Нигата-Саке фестиваль Niigata Sake Fair •Хугацаа : 3.14~3.15 •Хаана : Нигата хот •Харилцах хаяг : Нигата мужийн архи үйлдвэрлэгчдийн хоршоолол T. +81-25-229-1218 F. +81-25-229-1220
11	18	20	21
•Ангилал : Эрхүү муж/ Орос •Арга хэмжээний нэр : 'Байгаль тур' үзэсгэлэн •Хугацаа : 3. 25~3.27 •Хаана : Иркутск хот •Харилцах хаяг : Эрхүү мужийн Аялал жуулчлалын газар	•Ангилал : Пусан хот/Өмнөд Солонгос •Арга хэмжээний нэр : Пусан-Хот суурин газрын газар тариалангийн 11-р үзэсгэлэн •Хугацаа : 3. 26~3.29 •Хаана : BEXCO Олон улсын арга хэмжээний төв •Харилцах хаяг : Газар тариалангийн технологийн төв	27	28
•Ангилал : Дэгү хот/ Өмнөд Солонгос •Арга хэмжээний нэр : 12 дахь удаагийн Олон улсын ногоон эрчим хүч экспо (International Green Energy Expo & Conference-2015) •Хугацаа : 4. 1 ~ 4. 3 •Хаана : EXCO Олон улсын арга хэмжээний төв •Харилцах хаяг : Ногоон эрчим хүч зохион байгуулах алба T.+82-53-601-5371 http://www.energyexpo.co.kr/kor/	•Ангилал : Шаньдун муж/Хятад •Арга хэмжээний нэр : "Шар мөрний бэлчир 2015"- Олон улсын марафон гүйлтийн тэмцээн (2015-Yellow River Estuary (Dongying) International Marathon) •Хугацаа : 4. 2 (төлөвлөж байгаа) •Хаана : Дунин хот •Харилцах хаяг : T.+86-546-8928016	•Ангилал : Красноярск хязгаар/ Орос •Арга хэмжээний нэр : Сибирь-Эрдэнийн чулууны үзэсгэлэн •Хугацаа : 4. 2~4. 5 •Хаана : Красноярск хот •Харилцах хаяг : www.krasfair.ru T. +7 (391) 22-88-611	
8	9	10	11
•Ангилал : Красноярск хязгаар/ Орос •Арга хэмжээний нэр : Нефть хий, хими, уул уурхайн салбарын Сибирь-Гео форум •Хугацаа : 4. 15~17 •Хаана : Красноярск хот •Харилцах хаяг : www.krasfair.ru T. +7 (391) 22-88-611	•Ангилал : Тояама муж/ Япон •Арга хэмжээний нэр : Үйлдвэрлэлийн салбарын нэгдсэн үзэсгэлэн-Тояама 2015 •Хугацаа : 4. 23~4. 25 •Хаана : Тояама хот •Харилцах хаяг : Үзэсгэлэн зохион байгуулах алба T. +82-76-431-2015	•Ангилал : Улаан-Үд/ Орос •Арга хэмжээний нэр : "Буриадын аялал жуулчлал, амралт 2015" аялал жуулчлалын үзэсгэлэн •Хугацаа : 4. 17-4. 18 •Хаана : Улаан-Үд хот •Харилцах хаяг :	
15	16	17	
22	23	24	

"Миний мэдэх Зүүн хойд Ази сэдэвт" 2 дахь удаагийн эссэ бичлэгийн уралдаан

Уралдааны тухай

NEAR Холбооны Хэрэг эрхлэх газраас гишүүн орон нутгуудын 14-18-ны насны сурагчдийн дунд "Миний мэдэх Зүүн хойд Ази" сэдэвт 2 дахь удаагийн эссэ бичлэгийн уралдааныг зарласан билээ. Энэхүү уралдаанд Монгол улсаас 5, ОХУ-аас 22, БНСУ-аас 9, БНХАУ-аас 6, Япон улсаас 4 буюу нийт 46 сурагч оролцов. Тэргүүн байрт 1, дэд байрт улс бүрээс тус бүр 1 байр эзлүүлэв.

“Цайны соёлоос Зүүн хойд Азийг олж харах нь”



Тяньжин хотын 20-р дунд, ахлах сургуулийн 3-р ангийн сурагч
Жан Би Эйн

Өөр хоорондоо харилцан адилгүй улс орнуудаас адил төстэй шинжийг олъё гэвэл соёлоос л олж харж болно. Зүүн хойд Азийн хувьд тэрхүү адил төстэй шинжийг цайгаар төлөөлүүлж болно. Цай бол Хятадын Сычуан мужийн Мендин нутгаас гаралтай ч цайны амт үнэр нь Зүүн хойд Азид тархсан.

Мянган жилийн түүхтэй Хятадын цайны хэрэгсэл хамгийн нарийн хийцтэйгээр алдартай бөгөөд Ишин нутгийн цайны хэрэгсэл нь авсаархан, амар амгаланг илтгэнэ. Япон, Солонгосын цайны хэрэгсэлд Тан, Сун улсын үеийн хэв маяг их шингэж үлдсэн байдаг. Жижиг чимэглэл, хэрэгсэл нь энгийн сайхан харагддаг. Харин Оросын цайны эдлэл хэрэгсэл голдуу металаар хийгдсэн байдаг нь тус улс металл ашигт малтмалын нөөц баялагтай болохыг санагдуулдаг. Монголчууд сүүтэй цай уудаг, цайны аяга нь энгийн, элдэв чимэггүй байдаг нь уудам тал нутагт чөлөөтэй байдагтай холбоотой болов уу. Эдгээр зүйлс нь тус улсуудын хоорондын хэдэн мянган жилийн соёлын харилцаа холбоонд үүсэж тогтсон бөгөөд тэр дундаас цай Зүүн хойд Азид тархан, өөрчлөгдөн хувьсч хөгжсөн.

Намуухан өрөөнд нүдээ аниад гүн бодолд автана. Хамрын үзүүрт цайны үнэр ханхлахад тэрхүү үнэрт өөрийн эрхгүй татагдана. Цайны газрын үйлчлэгч бүсгүйн аягалж өгсөн цайнаас гарах үнэр өрөөгөөр нэл тархана. Цай бол Хятадын соёлын салшгүй нэгэхэн хэсэг юм. Хятад үндэстэн эртнээс бусад үндэстнүүдтэй, тухайлбал Зүүн хойд Азийн улсуудтай харилцахад цай гол үүрэгтэй байсан гэлтэй.

Цайны навч нь хосгүй ховор эрдэнэ мэт чухал бөгөөд Зүүн хойд Азийн улс хооронд эдийн засаг, худалдааг эрчимжүүлсэн. Цайны худалдаа нь өнө эртнээс өнөөг хүртэл Зүүн хойд Азийн улсуудтай худалдаагаар харилцахад гол хүчин зүйл болж, Зүүн хойд Азийн үндэстнүүдийн хооронд нөхөрлөлийн гэрч болж байна.


Өнөө үед цай нь Зүүн хойд Азид өргөн тархсан бөгөөд цаашид ч улам бүр өргөн дэлгэр тархах болно гэж бодож байна. Цай бол эдийн засаг, худалдааны харилцааны нэг хэсэг хийгээд талбайгаас урган гарсан технологи, улс, үндэстэн хооронд дамжин хөгждөг эд гэлтэй. Хятадын Воннан нутагт газар хөдлөлт болсны дараа ОХУ-ын Ерөнхийлөгч эмгэнэл илэрхийлж, Нанжиний залуучуудын Олимпоор Солонгос залуучууд сайн дурын үйлчилгээ үзүүлсэн зэрэг нь цайнаас үүдэлтэй үүссэн ард түмнүүдийн эртний нөхөрлөлийн үр дүн гэж хэлж болох юм.

Өөр улсын хөгжил дэвшилт соёлт гудамжаар алхаж байгаа жуулчин, Зүүн хойд Азийн зах зээлд хөл тавьсан гадаад худалдаачид хэн бүхэн бүгд л тухайн улсын цайг ууж үздэг. Цай хүрээгүй газар гэж дэлхийд байхгүй. Бүхий л эд зүйл түүх өгүүлнэ. Зүүн хойд Азийн бүх л улсуудын эдийн засаг, соёл, амьдралд тэрхүү цайны үнэр нэвт шингэсэн, цаашид ч мөнхөд үл мөрөө үлдээсээр байх болно.

Түүх баяжин, хорвоо дэлхий хувьсан өөрчлөгдөнө. Мянган жилийн дараа бүгд хуучран үгүй болоход ч цайны үнэр хүн төрөлхтний соёл иргэншил дунд анхилсаар байна гэдэгт би итгэлтэй байна. Цаг хугацаа улиран одож бидний амьдралын хэв маяг өөрчлөгдөвч цай мөнхөд оршин тогтнох ба Зүүн хойд Азийн өргөн уудам нутгаар үндэстэн улс хоорондын мөнхийн нөхөрлөлийг тээн дамжуулсаар авч явах болно.



“Солонгосын дунд, ахлах сургуулийн сурагчдаас сурч авсан зүйл”



Шиманэ мужийн Ицму
Ниши ахлах сургуулийн
2-р ангийн
сурагч Мишима Ауй

Өнгөрсөн зун би Шиманэ мужийн захиргаанаас зохион байгуулсан Солонгос-Японы дунд, ахлах сургуулийн сурагчдийн харилцааны хөтөлбөрт оролцсон юм. Солонгос улс бол Япон улстай хамгийн ойрхон орших хөрш улс хэдий ч хэл өөр, улс төрийн хувьд ч “Дайны үед япон цэргийн сексийн хэрэгцээнд Солонгос охидуудыг хүчээр хулгайлан боолчилж байсан явдал”-аас авахуулаад дайны дараах нөхөн төлбөр зэрэг төрөл бүрийн зөрчил, асуудалтай байдаг болохоор Солонгосын сурагчидтай би дотно нөхөрлөж чадах болов уу гэдэгт эргэлзэж байв. Гэвч бодит байдалд миний бодсноос огт өөр байлаа.

Би автобусанд солонгос сурагчтай зэрэгцэн суухад эхэндээ яриа үүсгэх хэцүү байсан ч солонгос сурагч эхлээд надтай яриа үүсгэсэн. Тэгэхдээ бүр япон хэлээр маш сайн ярихад нь би гайхсан. Түүний нэрийг Чэ Мин Жи гэдэг бөгөөд надаас нэг насаар дүү, солонгос хэл огт мэдэхгүй миний дэргэд япон хэлээр сайн ярихыг хараад солонгос хүмүүс их боловсролтой юм шиг санагдсан. Жаахан нүүр хагарч эхлэнгүүт бид урлаг соёл, комикс, төрсөн өдөр, гэр бүл гэх мэт янз бүрийн сэдвээр яриа өрнүүлэнгээ миний бодож байснаас ч илүүтэйгээр дотнотсон.

Эхлээд бид Хирүгэ далайн эрэгт их цэвэрлэгээ хийсэн. Хятад, Солонгосоос далайгаар дамжин ирсэн хогны 70%-ийг эзэлдэг Японы тэнгисийн байдлыг солонгос хүүхдүүдэд харуулсан. Солонгосын сурагчид өөрсдийнх нь орноос дамжин ирсэн тэрхүү далайн хог хаягдлыг хараад ихэд гэмшиж байгааг харсан. Энэ бүх үйл ажиллагааны үр дүнд Солонгост “Далайд хог хаяхыг хориглох хөдөлгөөн” өрнөвөл тун ч сайн байна. Дараах өдөр нь бид Ицму хотын Суба гоймонг хамт хийсэн. Солонгос сурагчдад суба гоймон хэрхэн хийхийг зааж өгөхийн тулд би өөрөө хийж үзүүлэхэд тэдний хэрхэн дагаж хийхийг харахад сэтгэл ч урамтай, гоймон ч амттай байлаа.

Дараагийн хөтөлбөр бол Ицму хотын олон улсын харилцааны танхимд болсон арга хэмжээ юм. Ицму хотын ахлах сургуулийн IAC хэмээх сайн дурын тусламжийн үйл ажиллагааны тайлангаас авахуулаад Солонгос, Японы нөхөрлөлийн талаар уран илтгэлийн тэмцээн болсон. Түүний дараагаар Солонгосын дунд, ахлах сургуулийн сурагчид дуу бүжиг, тэквандо зэрэг урлаг, спортын үзүүлбэр тоглолтоос толилуулсан. 8 дугаар сарын 16-ны өдөр Ицму-Лааны фестивалд бэлдэж бид хамтдаа “Солонгос, Японы харилцаа” сэдвээр зураг зурсан. Тэрхүү арга хэмжээнд оролцсон нь надад их дурсамж үлдээсэн. Бид салахынхаа өмнө бэлэг солилцох болж, би солонгос найз Чэ Мин Жид Японы комиксын эвлүүлдэг тоглоом бэлэглэхэд тэрээр ихэд баярласан.

2014 оны 7 дугаар сарын 23-ны өдөр миний хувьд хэзээ ч мартагдашгүй өдөр юм. Түүнээс хойш Чэ Мин Житэй мэйлээр харилцаж байгаа бөгөөд одоо миний сайн солонгос найз болсон. Тэрхүү хөтөлбөр ач холбогдлоо өгсөн, үнэхээр үр дүнтэй ажил болсон билээ. Солонгос, Японы харилцаа тийм сайн биш ч залуу үе бид өөр хоорондоо харилцаж чадсан. Солонгос-Япон, Хятад-Японы улс төрийн харилцааны ээдрээтэй энэ цаг үед залуу үе бид хоорондоо ийнхүү харилцах нь тэрхүү хурцадмал байдлыг зөөлрүүлэх үндэс болно гэж бодож байна. Бусдыг зэмлэн буруушаах бус давуу талыг нь олж хүлээн зөвшөөрч, зоригтойгоор харилцааг эхлүүлбэл сайн үр дүнд хүргэх болов уу. Иймд бидний залуу үе оролдлоготой, идэвхтэй байх хэрэгтэй.



2015

대구·경북 세계물포럼

Daegu & Gyeongbuk,
Rep. of Korea



2013 оны 3 сард Франц улсад “Дэлхийн усны 7-р форум” зохион байгуулах эрхийг Дэгү хот гардан авч байгаа нь



2014 онд болсон “Нагдун гол-Олон улсын усны өдрүүд” арга хэмжээ

“Дэлхийн усны форум -2015” удахгүй болно.

“Дэлхийн усны 7-р форум” 4 дүгээр сарын 12-ны өдрөөс 17-ны өдрийг хүртэл БНСУ-ын Дэгү хотноо болно. “Ус бидний ирээдүй” хэмээх уриан дор болох уг форумд усны салбарын эрдэмтэн, мэргэжилтнүүдээс гадна улс төр, ТББ, хэвлэл мэдээлэл, бизнесийн зэрэг холбогдох чиглэлийн төлөөлөл оролцох юм. 1997 онд зохиогдсон анхдугаар форумд 63 орны 500 гаруй хүн оролцож байсан бол 7-р форумд 170 гаруй орны 35000 хүн оролцох төлөвтэй байна.

“Дэлхийн усны форум”-ыг Дэлхийн усны хороо(WWC)-ноос 3 жил тутамд зохион байгуулдаг ба жил бүрийн 3 дугаар сарын 22-ны өдөр болдог Дэлхийн усны өдрөөр устай холбогдох асуудлыг шийдвэрлэх арга замыг хэлэлцэж, үүнийг хэрэгжүүлэхийн тулд улс төрийн тунхаг гаргах, бизнесийн хүрээнд усны экспо зохиохоор төлөвлөөд байна

“Дэлхийн усны форум”-ын түүхээс

Дэлхийн усны форум гэхээр хүмүүст сонин санагдаж магадгүй ч хүн төрөлхтний ирээдүйн төлөө усны асуудлыг шийдвэрлэх нь 21-р зууны гол зорилт болоод байна. Өнөөгийн байдлаар дэлхийн бараг тэн хагаст усны асуудлыг чухалчлан үзэж байгаа бөгөөд устай холбогдох асуудлыг шийдвэрлэхээр дэлхийн даяараа хичээж байна. Энэ мэтчилэн олон улсыг хамарсан устай холбоотой асуудлыг шийдвэрлэх зорилгоор усны мэргэжилтэн, төр засаг түүнчлэн олон улсын байгууллагын төлөөллөөс бүрдсэн Дэлхийн усны хороо 1996 онд анх байгуулагдаж дараа жил нь усны асуудлыг дэлхийн хэмжээнд шийдвэрлэхийн тулд “Дэлхийн усны форум”-ыг зохиох болсон.

Өмнөх форумын тухайд

Өнгөрсөн 18 жилийн хугацаанд 6 удаа зохиогдсон “Дэлхийн усны форум”-аас усны асуудлыг шийдвэрлэх хамтын зорилт гаргасан. “Дэлхийн усны 6-р форум”-аар “Time for Solution” уриан дор устай холбогдох 1000 гаруй арга технологийг нэгтгэн гаргах зэргээр дэлхийн усны асуудлыг шийдвэрлэхэд хичээл зүтгэл гаргаж байна.

Удахгүй зохиогдох “Дэлхийн усны 7-р форум”-ын тухайд


Өмнөх форумуудаар асуудал бэрхшээлийг шийдвэрлэх олон арга зам гарсан хэдий ч тэдгээрийн зэрэгцээ бодит байдал дээр хараахан шийдвэрлэгдээгүй устай холбоотой асуудлуудыг уг форумаар онцлон авч үзэх болно. Форумын хүрээнд улс төр, бүс, шинжлэх ухаан технологи гэсэн 4 гол сэдвээр арга хэмжээ болохоос гадна ард иргэдийг оролцуулсан форум, усны үзэсгэлэн зохино. Эхний арга хэмжээ бол “Дэлхийн усны форум” зохиогдохоос өмнө мэргэжлийн хүмүүсийн хүрээнд мэдээлэл солилцох бол, улс төрийн хүрээнд үүнийг хэрэгжүүлэхийг идэвхжүүлэх, хоёрдугаарт, яамдын сайд, их хурлын гишүүд, мужийн захирагч нар усны асуудлыг хэлэлцэнэ. Гуравдугаарт, бүс, хөрш зэргэлдээ бүсэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх талаар хэлэлцэнэ. Бүс бүрээр координатор

ажиллаж хэлэлцэх асуудлыг удирдах ба дэд бүс бүрээр нарийвчлан тусгайлан зохицуулагчид ажиллах болно. Шинжлэх ухаан, технологийн хороо нь “Дэлхийн усны 7-р форум”-ыг зохион байгуулах талын санаачлагаар байгуулагдсан. Энэ хорооноос устай холбогдох сүүлийн үеийн технологи, мэдээлэл солилцоог идэвхжүүлж, хөгжингүй орон, буурай орны ялгааг арилгах зорилт тавьжээ.

Түүнээс гадна дараах тусгай 3 хөтөлбөр явуулна.

Хөтөлбөрийн нэр	Агуулга
“Ус” нээлттэй өдөрлөг	Урьдчилан онлайнаар усны салбарын шилдэг арга туршлагаас шалгаруулна.
“Дэлхийн ус”	Дэлхийн хэмжээнд тулгарч буй усны хамгийн тулгамдсан асуудлыг шинжлэх ухаан технологиор шуурхай шийдвэрлэх арга зам, санааг санал болгох
Дэгү-Кёнбүг “Ус” шагнал	Дээрх хөтөлбөрөөс гарсан хамгийн шилдэг санааг шалгаруулан Дэлхийн усны 7-р форумын хаалтын ажиллагааны үеэр шагнал гардуулах

Түүнээс гадна форумын үеэр олон улсын усны үзэсгэлэнг Дэгү хотын EXCO олон улсын арга хэмжээний төвд гаргана. Уг үзэсгэлэнд улс орнуудын усны бодлого, тэргүүний технологиос танилцуулах ба үзэсгэлэнд оролцогчид усны аж үйлдвэрийн сүүлийн үеийн хандлагаас мэдэж авахын зэрэгцээ харилцаа тогтоон бизнесийн чиглэлээр хамтран ажиллагаагаа өргөжүүлэх боломжоор хангах юм. Мөн усны сэдэвт кино наадам, хөгжмийн наадам зэрэг төрөл бүрийн хөтөлбөр зохион явуулна.



Усны форум зохиож байсан хотууд

Усны форумын зурагт хуудас



1997 Marrakech, Morocco



2000 The Hague, the Netherlands



2003 Kyoto, Shiga and Osaka, Japan



2006 Mexico City, Mexico



2007 Istanbul, Turkey



2012 Marseille, France



Холбооны Хэрэг эрхлэх газарт 1 жил ажилласан гадаадын төрийн албан хаагчдийн сэтгэгдэл

2014 оны 3 дугаар сараас эхлэн 1 жилийн хугацаанд Холбооны Хэрэг эрхлэх газарт гишүүн орон нутгуудаас томилогдон ажилласан мэргэжилтнүүд удахгүй хугацаа нь дуусаад буцах гэж байна. Тус газраас NEAR Холбооны гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал, NEAR-Олон улсын форум, Холбооны 10-р Бүгд хурал зэрэг олон арга хэмжээг өнгөрсөн онд зохион явуулсан билээ. Арга хэмжээг зохиох бүрт чухал үүрэг гүйцэтгэсэн гишүүи орон нутгуудаас томилогдон ажилласан мэргэжилтнүүдийн сэтгэлээс хуваалцъя.

Чи Хун Жон | Хятад

Q1 Чи Хун Жон ажилдаа ирэхэд ч, ажил тараад гэртээ харихдаа ч унаанд суулгүй үргэлж цоглог алхаж байдаг санагдана. Холбооны Хэрэг эрхлэх газарт 1 жил ажилласан сэтгэгдлээсээ хуваалцана уу?



Нэг жил гэгч хугацаа модон дээр сууж байгаа болжмор дэрхийн нисэх адил нүд ирмэх зуур өнгөрчээ. Одоо эргээд харахад амжуулж хийгээгүй зүйлд харамсавч нэгэнт оройтжээ.

Солонгост амьдарч ажилласан өдрүүд ой тойнд минь тодхон байна. Дэгү хотноо болсон Холбооны гишүүн орон нутгуудын гадаад харилцааны мэргэжилтнүүдийн хурал, Жолланам мужид болсон Холбооны 10-р Бүгд хурал, Хабаровск хотноо болсон Олон улсын форум,

Кёнжу хотын түүх соёлын өвтэй танилцсан аялал зэрэг дурсамж дүүрэн өдрүүдийг мартахын аргагүй. Холбооны Хэрэг эрхлэх газарт 1 жил ажиллах хугацаандаа олон улсын чанартай арга хэмжээнээс туршлага олж авч, ихийг сурч мэдсэн. Түүнчлэн дээд сургуульд солонгос хэл сурч мэргэшсэн хэдий ч хэлний түвшингээ улам сайжруулсан. Түүгээр ч зогсохгүй солонгос хамт олны тусламж дэмжлэгээр ажилдаа хурдан далсан.

Нэг жилийн хугацаанд энэ газарт их дасчээ. Удахгүй буцна гэж бодохоор нэг талаар эвгүй ч нөгөө талаар эндээс олж авсан мэдлэг туршлагаа өвөртлөн дүүрэн баяртайгаар нутагтаа очно. Солонгост ирснээс хойш буруу зуршлаасаа салах, амьдралын үнэ цэнийг ойлгох зэргээр хувь хүний хувьд ч өөрчлөгдсөн. Эцэст нь нэг жилийн хугацаанд надад тусалж дэмжиж байсан бүх хүмүүст талархал илэрхийлье.

Б.Ундрах | Монгол улс

Q1 Холбооны Хэрэг эрхлэх газарт ажиллаад 1 жил болох гэж байна. Өөрийн сэтгэгдлээсээ хуваалцана уу?

Өнгөрсөн 2014 оны хавар Солонгос улсын



Пухан хот дахь Холбооны Хэрэг эрхлэх газарт ажиллахаар баяр хөөртэй, бас шинэ ажил, шинэ газарт ямар байх бол гэсэн бага зэргийн догдлол, түгшүүртэйгээр Инчоны нисэх буудалд бууж байсан тэр өдрөөс хойш бүтэн жил шахуу хугацаа өнгөрчээ. Өнөөдөр эргэн харахад, анх ирэхэд угтаж авсан намуун тайван Пухан хот, Хэрэг эрхлэх газрын найрсаг хамт олонд маш амархан дасаж, ажил мэргэжлийн хувьд ч, хувь хүний хөгжлийн хувьд ч олон зүйлийг шинээр сурч мэдэн, урагшилж дэвшсэн үр бүтээлтэй, бас хөгжилтэй сайхан цаг хугацааг энд өнгөрүүлжээ. Мөн анх ирж байхдаа солонгос хэл, Солонгос орныг сайн мэдэхгүй байсан болохоор бага зэрэг хүндрэл бэрхшээлүүд гардаг байсан бол одоо тодорхой хэмжээнд харилцах чадвартай болж, ажил төрлийн шугамаар болон амралтаараа олон газар, хотуудаар аялан тус орны түүх соёл, хүн зоно аж амьдралтай муугүй танилцаж амжсан. Тэр бүхний дундаас хамгийн ихээр сэтгэлд хоногшиж үлдсэн дурсамжууд гэвэл орос найз Аннагийн хамтаар Жэжу арлаар аялсан өдрүүд, мөн Инчоны дагуул хот Сунду хотын бүтээн байгуулалттай танилцсан тэр аялал санагдаж байна.

Q2 NEAR Холбооны Хэрэг газарт өөр улсын хүмүүстэй ажиллахад ямар байв?

Ажиллах хугацаандаа орос, хятад, япон, солонгос зэрэг олон орны хүмүүстэй нэг хамт олон болон ажиллаж, тэдний ажлын арга барил, туршлага, тухайн үндэстний соёл, сэтгэлгээний онцлогийг мэдэж авч, нэг нэгнээ таньж мэдэлцэн найз нөхөд болцгоолоо. Түүнчлэн NEAR холбооны үйл ажиллагаанд гар бие оролцон, өөрийн хувь нэмрээ бага ч болов оруулсан гэж бодоход сэтгэлд таатай байна. Миний хувьд өмнө нь Зүүн хойд Азийн талаар онцгойлон сонирхож судалдаггүй, ойлголт бүдэг байсан бол Хэрэг эрхлэх газарт ажиллах үеэр орчуулга хийх, хурал арга хэмжээнд оролцох, мэдээ материал бэлтгэх гэх мэт ажлын явцад гарч ирэх төрөл бүрийн мэдээллээр мэдлэгийн хүрээ аяндаа тэлж, уншиж мэдэх тусам энэ бүсийн улс орнуудын байдал, харилцааны асуудал өөрийн эрхгүй сонирхол татах болсон. Эндээс олж авсан энэ бүх туршлага, мэдлэг миний цаашдын ажилд ч үр дүнгээ өгч, сайнаар нөлөөлнө байх гэж бодож байна.

Q3 Эцэст нь Холбооны Хэрэг эрхлэх газрын хамт олонд хандаж хэлэх үг байна уу?


Энэ бүх хугацаанд үргэлж надад тусалж дэмжин харамгүй зааж зөвлөж

байсан Хэрэг эрхлэх газрын хамт олон болон Холбооны ажлыг саадгүй явуулахад санаа тавьж, байнга хамтран ажилладаг Монгол улсын мэргэжил нэгт нөхөддөө бүгдэд нь чин сэтгэлийн талархал илэрхийлж, цаашдын ажилд амьдралд нь сайн, сайхан бүхнийг хүсье.

Анна Раман | ОХУ

Q1 Холбооны Хэрэг эрхлэх газарт ирж ажиллаад хэдийнээ нэг жилийн хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд танд хамгийн гүн сэтгэгдэл үлдээсэн зүйл юу байсан бэ?

Холбооны хэрэг эрхлэх газарт ажилласан хугацаанд хамгийн мартагдашгүй үйл явдал бол Хабаровск хотод болсон Холбооны Олон улсын форум байлаа. Энэ арга хэмжээг зохион байгуулахтай холбоотой асуудлаар Хабаровскийн хязгаарын Засаг захиргаатай уулзалт, хэлэлцээ хийхээр хэд хэдэн удаа томилолтоор явж, Хэрэг эрхлэх газрын оффист ч нэлээн ачаалалтай ажилласан.



Энэ бүхний үр дүнд би олон улсын том арга хэмжээг зохион байгуулах талаар үнэлж баршгүй туршлага олж авсан билээ. Түүнчлэн форумыг зохион байгуулалтын асуудлыг шийдэх үеэр орон орны төрийн албан хаагчдын аяллын баримт бичгийг бүрдүүлэх үеэрээ БНХАУ, Япон, БНСУ, Монгол улсын хууль эрх зүйн орчинг илүү их ойлгож мэдэж авсны зэрэгцээ Олон улсын форумд оролцогчдын хэлэх үг, илтгэлийг орчуулах үеэрээ Зүүн хойд Азийн бүс нутгийн онцлог, нэг асуудлаарх орон орны судлаачдын өөр өөр үзэл бодол, байр суурийг мэдэж авч, бүсийн зөрчилдөөнтэй асуудлыг илүү гүнзгийрүүлэн судлах завшаан болсон.

Форумыг зохион байгуулахаар бэлтгэж байх үед өөр хоорондоо ойлголцоход хэлний бэрхшээлтэй хэдий ч ХЭГ-ийн хамт олон бүгд нэгэн зорилгын доор нэгдэж, нягт хамтран ажиллан хэн хэнээ бараг үггүйгээр ойлголцож байсан нь надад мэдрэгдэж байсан юм. Энэхүү арга хэмжээ нь мэргэжлийн ур чадварыг маань дээшлүүлээд зогсохгүй шинэ найз нөхөд, шинэ танилуудтай болж, харилцаа холбоо тогтоох боломжийг олгосон.

Q2 Солонгос улсад өнгөрүүлсэн хамгийн сонирхолтой цаг үеийнхээ тухай ярьж өгнө үү.

Намайг Холбооны Хэрэг эрхлэх газарт томилолтоор илгээсэн нэг зорилго нь Эрхүү муж болон БНСУ-ын хоорондын хамтын ажиллагааны хөгжлийн чиг хандлага, боломжийг судлах явдал байсан. Үүнтэй холбоотойгоор олон янзын газраар явж үзэх боломж надад тохиосон юм. БНСУ нь тээврийн

системийг сайтар хөгжүүлснээр энэ сайхан орны хамгийн алс холын буланд ч тав тухтай аялж очих боломжийг бүрдүүлжээ. Очсон газруудаас хамгийн их сонирхол татаж, гүн сэтгэгдэл үлдээсэн нь гэвэл Инчоны Сунду дүүрэг, Жэжү арал болон буддын шашны Үнмүнса хийд байлаа.

Сунду бол ажил хэрэгч, эрчтэй хөгжиж буй өнөөгийн Солонгос орныг жинхэнээр төлөөлөн харуулахуйц, олон улсын томоохон корпораци, олон улсын шаардлагад нийцсэн бизнес төвүүд, боловсролын байгууллагууд бүхий чөлөөт эдийн засгийн бүс юм. Энэ бүсийг «Smart city» гэсэн үзэл санаатай уялдуулан хөгжүүлж байна.

Харин Жэжү арал руу аялсан маань огт урьдчилан төлөвлөгдөөгүй, гэнэтийн шийдвэр байсан бөгөөд тэр тусмаа мартагдамгүй адал явдлаар дүүрэн аялал болсон юм. Богино хугацаанд тав тухтай парк, том том музей, уламжлалт зах зэргийг үзэн нутгийн иргэдтэй харилцаж, богино боловч сайхан цаг хугацааг өнгөрүүлэх аз тохиосон билээ. Энэ аралд зочилсныхоо дараа хамгийн сайхан сэтгэлтэй, тусч уриалгахан хүмүүс энд амьдардаг гэдэгт би бат итгэх болсон.

1500 жилийн түүхтэй, буддын шашны эмэгтэйчүүдийн хийд Үнмүнса нь уран зураг шиг үзэсгэлэнт байгаль дунд оршдог бөгөөд асар том хийд байсан нь намайг ихээр гайхан бишрүүлсэн. Тус хийд нь өнөөдөр Солонгос улс дахь буддын шашны хамгийн том төв хэмээн тооцогдож байна.

Q3 Эцэст нь Хэрэг эрхлэх газрын хамт олон хандаж хэлэх үг байна уу?

Энэ завшааныг тохиолдуулан ХЭГ-ийн нийт хамт олон, Холбооны Ерөнхий нарийн бичгийн дарга асан Ким Жэ Хю нарт биднийг ажиллаж амьдрах тав тухтай нөхцлөөр хангаж байсанд нь чин сэтгэлийн талархал илэрхийлье. Тэр дундаа Орос хэлний мэргэжилтэн Чой Жу Хваг онцгойлон дурьдахыг хүсэж байна. Тэр хошин шогийн гайхалтай мэдрэмж, орос сэтгэлгээтэй хүн бөгөөд бид энэ нэг жилийн хугацаанд маш ойр дотно ажиллаж, зөвхөн хамт ажиллагсад төдийгүй сайн найз нөхөд болсон билээ.

2016 он хүртэл Эрхүү муж нь ЗХАБНЗХХ-ны Тэргүүлэгчээр ажиллаж байгаа учир миний хувьд эх орондоо буцаж очоод Холбооны ХЭГ-тай цаашид нягт хамтран ажиллана гэж найдаж байна.

Холбооны бүхий л гишүүн орон нутгуудыг 2015 оны Эрхүү мужид болох Ажлын хорооны хурал, 2016 онд Эрхүү мужид болох Холбооны Бүгд хуралд оролцоход нь баяртайгаар хүлээж байх болно.



The Association of Northeast Asia Regional Governments



Зүүн хойд Азийн бүс нутгийн засаг захиргаадын холбоо

The Association of Northeast Asia Regional Governments

Хаяг. Кёнсанбүг муж, Пухан хот, Намгү Жигугну 394(Жигугдун 601) Пухан Техно парк 3 давхарт

Утас. +82-54-223-2384 **Факс.** +82-54-223-2309 **E-mail** neargov@hotmail.co.kr **Website** www.neargov.org